



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 4/112

Мандалговь

Тусгай зөвшөөрлийн эрх сунгах,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дүгээр зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Сайнцагаан сумын "Тойн хайрхан" ХХК-ны хүнсний дэлгүүрийн архи согтууруулах ундаа /спиртийн өндөр болон сул агууламж/ худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2018 оны 5 дугаар сарын 4-ны өдрөөс 2020 оны 5 дугаар сарын 4-ны өдөр хүртэл хугацаагаар сунгасугай.

Хоёр. Сайнцагаан сумын "Говийн тэнгэр", "Алтанцант", "Хос гарьд магнаг", "Ихэр гэр чулуут", Эрдэнэдалай сумын "ПББД", Дэлгэрцогт сумын "Амар баярсод дөлгөөн", Луус сумын "Миний найдвар", Сайхан-Овоо сумын "Төгрөг баянхайрхан", Цагаандэлгэр сумын "Хайрхан хонгор" ХХК-иудын тусгай зөвшөөрлийн эрхийг 2018 оны 5 дугаар сарын 4-ны өдрөөс хүчингүй болгосугай.

Гурав. Тусгай зөвшөөрлийн эрх олгогдсон "Тойн хайрхан ХХК-ны худалдааны газрын ажиллах цагийн хуваарийн 09.00 -21.00 цаг хүртэл хугацаагаар баталсугай.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн эрхийг сунгасан, хүчингүй болгосон шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Ц.Сугаржав), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж. МӨНХЧУЛУУН

0200636

